



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/2023

Мөрөн сум

Барилгын ажлыг хүлээж авах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд баригдсан Биеийн тамирын гадна талбайн тохижилт (Дэлгэрмөрөн цогцолбор ерөнхий боловсролын сургууль)-ын ажлыг хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

П.Даваа-Очир (Мэргэжлийн хяналтын газрын Өргөх байгууламжийн хяналтын улсын байцаагч)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Л.Бямбасүрэн (Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын улсын байцаагч, хошууч)

Д.Оюун-Эрдэнэ ("Хөвсгөл барилга захиалагчийн төв" ОНӨААТҮГазрын Ерөнхий инженер)

Ч.Лхагвамядаг (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Н.Нямдорж ("Нануто" ХХК-ийн Захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Ч.Баянбилэг ("Хөвсгөл хүрмэн" ХХК-ийн Захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Б.Гантулга (Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн Захирал)

О.Мөнхболд (Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн нягтлан)

А.Доржсүрэн (Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн нярав)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Барилгын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилгын ажлыг хүлээж авахтай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав)-д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга, байгууламжийн ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР